



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/718

Ховд

Цэвэр усны даралтын насос /Зэрэг Шим-Ус Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар/-н ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Гранд лүүк” ХХК-ий хийж гүйцэтгэсэн Цэвэр усны даралтын насос /Зэрэг Шим-Ус Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Н.Ганбат

- “Шим-ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар дарга

Гишүүд: Н.Цацралцэцэг

- Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Р.Янжмаа

- Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн

М.Баярт

- Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга

М.Нансалмаа

- “Шим-ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер

Ц.Цолмонбаатар

- Стандарт хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Х.Азбаяр

- “Зэрэг шим-ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар дарга

Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга
Н.Алдар - “Гранд лүүк” ХХК-ий захирал

Нарийн бичгийн
дарга: С.Өнөржаргал - Газрын харилцаа барилга хот байгуулалтын
газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Гранд лүүк” ХХК-ий хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Н.Ганбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН